

Эрүүл мэндийн ажилтанд 2021 онд нийт 38 ажилтанд 1-р улиралд 12,090,613 төгрөг, 2-р улиралд 12,442,405 төгрөг, 3-р улиралд 11,231,483, 4-р улиралд 11,163,530 төгрөг нийт 46,928,031 төгрөгийн үр дүнгийн урамшууллыг олгосон байна.

Хөдөлмөрийн тухай хуулийн 72.1 дэх заалтын дагуу 22 цагаас 06 цаг хүртэлх хугацаанд ажилласан эрүүл мэндийн ажилтнуудад "шөнийн цаг ажилласны нэмэгдэл"-ийг 1 цаг тутам 1000 төгрөгөөр тооцож 2021 онд шөнийн цагийн нэмэгдэлд 1-р сард 496,000, 2-р сард 392,000, 3-р сард 496,000, 4-р сард 472,000, 5-р сард 360,000, 6-р сард 624,000, 7-р сард 256,000, 8-р сард 248,000, 9-р сард 240,000, 10-р сард 304,000, 11-р сард 384,000, 12-р сард 328,000 төгрөг нийт 4,600,000 төгрөгийг олгосон байна.

Ур чадварын нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлтийг хангасан албан хаагчдад 2021 онд 1-р сард 1,144,614, 2-р сард 507,578, 3-р сард 867,491, 4-р сард 2,291,278, 8-р сард 1,108,264, 10 сард 1,006,751, 11 сард 886,850, 12 сард 681,591 нийт 8,404,417 төгрөгийн ур чадварын нэмэгдлийг олгосон байна.

ЭМТ –ийн няравт үндсэн цалингийн 8%-аар нэмэгдэл хөлс олгодог. 2021 онд нийт 435,910 төгрөгийн эд хариуцагчийн нэмэгдэл хөлс олгосон байна.

Албан хаагчдад сар бүр олгодог хоол хөнгөлөлт ,унааны зардлыг өдрийн 1000 төгрөг, аймагт албан томилолтоор 14000 . УБ хотод томилолтоор 16000, сумдад 12000 төгрөгөөр тооцож олгож байна

Ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэх асуудлын хүрээнд 2021 онд байгууллагын нийт 36 ажилтныг тус бүр 350,000 төгрөгөөр буюу нийт 12,600,000 төгрөгийн эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг, шинжилгээнд хамруулсан байна.

УБ хотын Улсын Клиникийн нэгдүгээр төв эмнэлгийн "Эрүүл мэндийг дэмжих төв"-тэй хамтран ажиллаж нарийн мэргэжлийн эмч нарын 10 төрлийн үзлэг шинжилгээнд дотор, нүд , мэдрэл , эмэгтэйчүүд, зүрхний эхо, бамбайн эхо, ходоодны дуран, рентген, зүрхний цахилгаан бичлэг, уушиг чиглэлээр ЭМТ-ийн 33 албан хаагчдыг хамруулсан .Албан хаагчдын үзлэг, шинжилгээний хариуг нэгдсэн журмаар ЭМТ-ийн дотор судлалын эмч Б.Ган-эрдэнэд хүлээлгэн өгч эрүүлжүүлэх эмчилгээг эрчимжүүлж ажиллаж байна.

Тайлан бичсэн *Д. Алтанцэцэг* Д.Алтанцэцэг